

УЛС ТӨР



- СОНИРХЛЫН БҮЛЭГ, НИЙТИЙН АШИГ СОНИРХЛЫГ ИЛЭРХИЙЛЭГЧ
- УЛС ТӨРИЙН НАМ АРДЧИЛЛЫГ ТЭЭГЧ БОЛОХ НЬ
- СОНГУУЛЬ-ТӨЛӨӨЛЛИЙН АРДЧИЛЛЫН ҮНДЭС
- СОНГУУЛИЙН ТОГТОЛЦООНЫ ОНЦЛОГ
- ТӨР ОРШИХУЙН УЧИР
- ТӨР ИРГЭНИЙ ХАРИЛЦААГ БЭХЖҮҮЛЭХ НЬ
- АРДЧИЛЛЫН ОНОЛУУД БА БОДИТ БАЙДАЛ
- АРДЧИЛАЛ ХҮН ТӨРӨЛХТНИЙ ҮНЭТ ЗҮЙЛ БОЛОХ НЬ



Системийн онол ХХ зууны 20-иод оны үеэр биологийн шинжлэх ухаанд анх үүссэн гэж үздэг. Людвиг фон **Берталанфи** эд эсийг судлан, түүнийг харилцан хамааралтай элементийн нийлбэр цогц буюу гадаад орчинтой холбоотой систем гэж тодорхойлсон байна.

ТОГТОЛЦООНЫ ДЭД
СИСТЕМ(ИНСТИТУЦИОНАЛЬ)

МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦААНЫ ДЭД
СИСТЕМ (КОММУНИКАЦИ)

ХЭМ ХЭМЖЭЭ, ЗОХИЦУУЛАЛТЫН ДЭД
СИСТЕМ



Улс төр гэдэг бол нийгэм дэх үнэт зүйлсийг эрх мэдэлд тулгуурлан хуваарилан байршуулах үйл ажиллагаа

Д. Истон

ТОГТОЛЦООНЫ ДЭД СИСТЕМ (ИНСТИТУЦИОНАЛЬ)





УЛС ТӨРИЙН ИНСТИТУТ





УЛС ТӨРИЙН ИНСТИТУТ



МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦААНЫ ДЭД СИСТЕМ

Мэдээлэл-харилцааны дэд систем нь улс төрийн системийн бүрдэл хооронд холбоо тогтоох, төр болон улс төрийн институтэд мэдээлэл дамжуулах **«сувгийн»** үүрэг гүйцэтгэдэг.

Улс төрийн системийн үйлчлэл нь хүмүүсийн авч буй **мэдээллийн түвшин**, хүрээнээс ихэд шалтгаалдаг. Хүмүүс тодорхой мэдээлэл, мэдлэгтэй байж л улс төрийн аливаа үйлдлийг **үнэлэх боломжтой** байдаг. **Мэдээллийн хэрэгсэл эрх чөлөөтэй** байна гэдэг нь зөвхөн тунхаглаж бахархдаг зүйл гэхээсээ илүү хувь хүнд сонголт хийх эрхийг өөрт нь олгож байгаагийн гол баталгаа болдог байна.






УЛС ТӨРИЙН ИНСТИТУТ



ХЭМ ХЭМЖЭЭ ЗОХИЦУУЛАЛТЫН ДЭД СИСТЕМ

Хэм хэмжээ-зохицуулалтын дэд систем нь улс төрийн амьдрал дахь хүмүүсийн үйл байдал болон бусад объектын чиг үүргийг тодорхойлох хэм хэмжээнээс бүрдэнэ. Тухайлбал, шаардлага дэвшүүлэх, эл шаардлагыг шийдвэр болгох, шийдвэрийг хэрэгжүүлэх үйл явцад оролцох хүмүүсийн үйл байдлыг энд дурьдаж болно.

ДАДАЛ ЗАНШЛЫН



ХУУЛЬ ЗҮЙН



УЛС ТӨРИЙН ИНСТИТУТ



УЛС ТӨРИЙН СИСТЕМИЙН ЧИГ ҮҮРЭГ



Уг асуудлыг Г.Алмонд нарийн судалж гаргажээ. Тэрээр улс төрийн системийн үндсэн хоёр бүлэг болох “оролт”, “гаралт”-ын чиг үүрэг байдаг гээд тэдгээрийг тодорхойлсон юм.



СОНИРХЛЫН БҮЛЭГ НИЙТИЙН АШИГ
СОНИРХЛЫГ ИЛЭРХИЙЛЭГЧ



СОНИРХЛЫН
БҮЛЭГ

СОНИРХЛЫГ ИЛЭРХИЙЛДЭГ

УЛС ТӨРИЙН
НАМ

СОНИРХЛЫГ НЭГТГЭДЭГ

ТӨР

СОНИРХЛЫГ ХЭРЭГЖҮҮЛДЭГ





- ❑ Аливаа нийгэмд тодохой хүмүүсийн эрх ашиг зөрчигдөж, улмаар тэрхүү зөрчигдсөн эрх ашгаа хамгаалахын тулд хүмүүс сонирхлын бүлэгт нэгддэг.
- ❑ Хувийн ашгийн төлөө бус бүлгийн буюу нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэх зорилгоор иргэдээс сайн дураар үүсгэн байгуулагддаг.

Лобби

✓ **Онцгой ашиг сонирхлоо** хэрэгжүүлэх зорилгоор төр засгийн байгууллагад зорилго чиглэл бүхий нөлөө үзүүлэхийг хэлнэ.

- XVII зууны 40-д оноос Их Британы парламентын ордны барилгын хонгил, хүлээх өрөөг **лобби** хэмээн хэлдэг байсан бөгөөд үүгээр төлөөлөгчид саналаа өгөхдөө явахдаа нэгдсэн хуралдаанд оролцох эрхгүй сонирхогч хүмүүстэй уулздаг газар нь байжээ.



Лоббизм гэдэг нь товчхондоо төрийн бүхий л байгууллагад шахалт үзүүлэх, нөлөөлөх замаар хувь хүн болон янз бүрийн сонирхлын бүлгүүд ашиг сонирхолдоо нийцсэн шийдвэр гаргуулах үйл ажиллагааг нэрлэдэг.

Улс төрийн нам хүчирхэг, үйл ажиллагаа нь үр ашигтай байхын хэрээр сонирхлын бүлгүүдийн улс төрийн бодлого боловсруулахад үзүүлэх нөлөө нь бага байдаг аж. Харин улс төрийн намууд сул дорой байхын хэрээр “лоббидох” нь далайцтай болдог байна.

5.КЭМБРИЖИЙН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХИЙГ ДЭМЖИХ ЛОББИ БҮЛЭГ


БҮЛГИЙН АХЛАГЧ: Н.Учрал

БҮЛГИЙН ГИШҮҮД: Х.Ганхуяг, Г.Амартүвшин, Г.Дамдинням, С.Батболд, Х.Булгантуяа, Д.Батлут нар.


ЗОРИЛГО: Монгол хүүхдүүд дэлхийд үнэлэгдэх, өрсөлдөх боловсролыг нийслэлд ч орон нутагт ч тэгш эзэмших боломжийг боловсролын тогтолцоонд бий болгох. Кэмбриж, лаборатори гэж ялгадаг байдлыг арилгаж бүгд тэгш боловсрол эзэмших боломжийг бий болгох зорилготой.



Сонирхлын бүлэгт хүмүүс яагаад нэгддэг вэ?



СОНИРХЛЫН БҮЛГҮҮДИЙН ҮНДСЭН ҮҮРЭГ



*СОНИРХОЛ ИЛЭРХИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА:



Америкийн судлаач А. Алмонд сонирхлын бүлгийг өөрсдийнх нь өвөрмөц байдал, дотоод зохион байгуулалтаас хамааран доорх шинжид хуваан авч үзсэн байна. Үүнд

| Аномик | Эвсэл холбооны | Эвсэл холбооны бус | Байгууллагажсан |
|---|---|---|--|
| Тодорхой зохион байгуулалтгүй хэсэг бөөн хүмүүсийн цугларалт бослого үймээн | Өөрийн гэсэн тодорхой зорилго, чиглэлтэй зохион байгуулалттай бүлэг | Зохион байгуулалтгүй боловч аномик бүлгээс ялгаатай нь яс үндэс, угсаа гараошл, арьс өнгө, шашин шүтлэг, нас хүйс зэрэг нийтлэгээрээ хамрагддаг | Цэрэг зэвсэглэл, арми, сүм хийд зэрэг субъектийг шууд удирдлаган дор зохион байгуулалттай үүсгэн байгуулагддаг |

*СОНИРХЛЫН БҮЛГИЙН ЧИГ ҮҮРЭГ



2017 ОНЫ ХУВИЛБАР

A- 34. Нийгэм дэх олон бүлгийн сонирхлыг илрүүлэн гаргах чиг үүргийг юу гэж нэрлэх вэ?

- A. Страфикаци B. Агрегаци C. Интеграци D. Даяарчлал E. Артикуляци

B- 34. АНУ-ын улс төр судлаач А.Алмонд өөрийн гэсэн зорилго чиглэлтэй зохион байгуулалттай бүлгийг сонирхлын бүлгийн ямар хэв шинжид хамаарна гэж үзсэн вэ?

- A. Эвсэл холбооны бус бүлэг B. Аномик бүлэг C. Эвсэл холбооны бүлэг
D. Байгууллагажсан бүлэг E. Үзэл сурталжсан бүлэг

C-34. Дараах бодомжуудын аль нь Аномик бүлгийг илэрхийлж байна вэ?

- A. Хүмүүс голдуу яс, үндэс угсаа гарал, арьсны өнгө, шашин шүтлэг, нас хүйс зэрэг нийтлэгээрээ хамрагддаг бүлэг
B. Өөрийн гэсэн зорилго чиглэлтэй зохион байгуулалттай бүлэг
C. Тодорхой зохион байгуулалтгүй хэсэг бөөн хүний цугларалт, бослого үймээн
D. Цэрэг зэвсэглэл, арми, сүм хийд зэрэг субъектын шууд удирдлаган дор зохион байгуулалттай үүсгэн байгуулагддаг бүлэг
E. Эдийн засаг, бизнесийн бүхий л салбарын эвсэл холбоод, ажил олгогчдын болон ажил хайгчдын тодорхой зорилготой бүлэглэл

D-34. Сонирхлын бүлэг нь улс төрийн үйл ажиллагааны дараах төрлүүдийн алийг нь голлон хэрэгжүүлдэг вэ?

- A. Сонирхлыг хэрэгжүүлэх B. Сонирхлыг дамжуулах C. Сонирхлыг нэгтгэх
D. Сонирхлыг илэрхийлэх E. Сонирхлыг боловсруулах